

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БУРГАСТАЙ
ДАХЬ ГААЛИЙН ХОРООНЫ ДАРГА
Д.ЭРДЭНЭСҮХ ТАНАА

2023.02.12 № 17

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 сарын 05 өдрийн Б/08 тушаал Мэргэжлийн хяналтын хилийн хорио цээрийн хэлтэс Гаалийн байгууллагад шилжин ирсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллах шаардлагатай байна

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 100 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702000035

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	9.7	22.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,357,231.2	2,321,136.4
Нийт хөрөнгийн дүн	2,366,983.6	2,343,334.9
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,366,983.5	2,343,334.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,366,983.5	2,343,334.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	599,986.1	1,370,456.4
Үйл ажиллагааны зардлын дүн	677,598.4	800,955.1
Үйл ажиллагааны үр дүн	-77,612.2	569,501.3
Үйл ажиллагааны бус үр дүн	27.5	
Үйл ажиллагааны нийт үр дүн	-77,639.7	569,501.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,444,623.6	2,366,983.5
Тайлант оны үр дүн	-77,639.7	569,501.4
Эцсийн үлдэгдэл	2,366,983.5	2,343,334.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	582,978.9	725,240.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	542,797.6	666,441.8
Үйл ажиллагааны ЦМГ	40,181.3	58,799.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	40,181.3	58,799.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	720,603.1	608,992.6
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0	0
Урсгал зардал	720,603.1	720,603.1
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	720,603.1	
Улсын төсвөөс санхүүжих	720,603.1	720,603.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,229.4

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.6 сая төгрөгийн алдаа¹, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 5.7 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд 1.9 сая төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" заалтыг зөрчсөн байна.
- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 5.7 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 16.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 заалт албан шаардлага, 2.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Амралтын цалин, үндсэн цалинг давхардуулан 0.2 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал 3.7 сая төгрөгийг дутуу тооцож олгосон нь Гаалийн ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/249 тушаалын хавсралт "Гаалийн улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох" журмын 3 дугаар зүйлийн 3.2-т "Гаалийн улсын байцаагчийн улирлын үр дүнгийн шагнал тооцохдоо сар бүрийн ажлын үр дүнгийн дагуу олгогдох шагналын хувиар тооцож олгоно" гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин тээвэр шатахууны зардлаас 0.7 сая төгрөгийн, жолоочийн замын хуудас автомашины спидометр зөрүүтэй 1.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Хил дээр ажиллаж байгаа ажилчдад хоол хүргэхэд сар тутам 2 удаа явж 2.7 сая төгрөгийн шатахууны зардлыг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах"; 4.2.3-т

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэсэн заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах; гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашин талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашин талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй, автомашиныг парклаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох,


Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая. төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн	1	5.7	1	5.7	-	-	1	5.7	-	-	-	-



татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн												
Зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан	1	1.9			1	1.9	1	1.9	-	-	-	-
Дүн	2	7.6	1	5.7	1	1.9	2	7.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										Хуул ь, хяна лты н байг уулл агад шил жүү лсэн асуу дал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөм ж		Хариуцлага тооцуулах албан шаардлага					
	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Албан тушаал тны тоо	То о	Дүн		
Амралт, цалин давхардан цалин илүү олгосон	1	0.2	1	0.2	-	-	-	-	-	-	-	-		
Шатахууны зардал, спидометр заалт зөрүүтэй	1	1.8	1	1.8	-	-	-	-	-	-	-	-		
Шатахууны зардлыг хэмнээгүй	1	2.7			1	2.7	-	-	-	-	-	-		
Тод дэвсгэр бүхий дугаар ашиглаагүй	1			-	-	-	1	-	-	-	-	-		
Дүн	4	8.5	2	5.8	2	2.7	1	-	-	-	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой								



Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

Шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлсэн	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Тод дэвсгэр бүхий дугаар ашиглаагүй	1	-	-	-			1	
Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	2				1		1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-